



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А004

Жаргалтхаан сум

Агаар бохирдлын эх үүсвэрийн
тооллого зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.2, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь заалтууд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дугаар тушаалаар батлагдсан "Агаарын бохирдлын эх, үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх журам", Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/713 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын хэмжээнд агаар бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. -

Ажлын хэсгийн дарга: Н.Отгонбаяр-Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Г.Түмэнжаргал- Байгаль орчны

асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Х.Намхайдорж - Байгаль хамгаалагч

Г.Жавзанжамъян - 1 дүгээр багийн Засаг дарга

Э.Аранжил - 2 дугаар багийн Засаг дарга

М.Өсөхжаргал - 3 дугаар багийн Засаг дарга

А.Мөнх-Амгалан - 4 дүгээр багийн Засаг дарга

Б.Жаргал – 5 дугаар багийн Засаг дарга

А.Оюунтунгалаг - Татварын улсын байцаагч

Т.Төгөлдөр - Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Э.Жамсранжав-Эрэн хайх, аврах бүлгийн дарга


Д.Мөнхбаяр-Засаг даргын Тамгын газрын нярав

Э.Одгаваа- Иргэний танхимын ажилтан

2.

2. Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг сумын хэмжээнд 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 01 дүгээр сарын 20-ний өдөр хүртэлх хугацаанд холбогдох журмын дагуу зохион байгуулж танилцуулах, мэдээ судалгааг хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Н.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГАНБАТ

